



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХЭА-2023/191/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.open.audit.mn

Чингис хот

2023 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Эрдэнэбаатар
Утас: 70562112

Аудитын менежер: Д.Оюунтуяа
Утас: 99775390

Аудитор: Н.Туяа
Утас: 99799709

Цахим хаяг: www.open.audit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баяр
Утас: 70-56-21-47, Факс: 70-56-21-12
E-mail: khentii@audit.gov.mn

2023.02.20 № 28

танил _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэнтий аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хэнтий аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тус сангийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайлангаар хувь хүмүүсээс авах авлага 2,098,375.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Тайлант онд үндсэн дансанд зээлийн эргэн төлөлтөөс 630,269.6 мянган төгрөг төвлөрснийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна. Нэмэлт дансаар 2,359,827.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, 4,200.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, 1,799,744.8 мянган төгрөгийг зарцуулж, 564,282.2 мянган төгрөгийн улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Тус газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар байгууллагын ажилтнуудын сургалтыг зохион байгуулах, туршлага судлахтай холбоотой томилголт, шатахуун, хоол цайны материал, бичиг хэргийн зардалд 14,763.1 мянган төгрөгийг зарцуулсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн холбогдох заалтад нийцээгүй, шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих мэдээллийг 74.8 хувьтай мэдээлж, таван сая төгрөгөөс дээш орлогын 135020,0 мянган төгрөгийн 4, зарлагын 1863278.4 мянган төгрөгийн 171 гүйлгээг мэдээлээгүй зөрчил илэрсэн нь санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг байна.

Бусад асуудлын хэсэг

Хэнтий аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн үйл ажиллагаанд төсвөөс олгох санхүүжилтийг батлагдсан төсвөөс 15,000.0 мянган төгрөгөөр илүү олгосныг дээд шатны төсөв захирагч анхаарах нь шаардлагатай.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭРДЭНЭБААТАР

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,442,645,252.00</u>	<u>2,098,375,656.80</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	-
312	Банканд байгаа бэлэн мөнгө	-	-
31211	Төрийн сангийн харилцах		
33	АВЛАГА	1,442,645,252.00	2,098,375,656.80
33300	Татаас, санхүүжилтийн авлага	25,318,700.00	-
335	Бусад авлага	1,417,326,552.00	2,098,375,656.80
3352	Хувь хүмүүсээс авах авлага	1,417,326,552.00	2,098,375,656.80
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,442,645,252.00</u>	<u>2,098,375,656.80</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,442,645,252.00</u>	<u>2,098,375,656.80</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,442,645,252.00	2,098,375,656.80
512	Хуримтлагдсан үр дүн	1,442,645,252.00	2,098,375,656.80
51210	Өмнөх үеийн үр дүн	1,843,050,248.00	1,442,645,252.00
51220	Тайлант үеийн үр дүн	(400,404,996.00)	655,730,404.80
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,442,645,252.00</u>	<u>2,098,375,656.80</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	792,556,250.00	2,364,027,000.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	40,000.00	-
120	Нийтлэг татварын бус орлого	40,000.00	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	40,000.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	40,000.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	792,516,250.00	2,364,027,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	792,516,250.00	2,364,027,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	80,335,250.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	712,181,000.00	2,359,827,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	4,200,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,138,671,896.00	1,708,296,595.20
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,138,671,896.00	1,708,296,595.20
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	29,045,900.00	2,700,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,160,000.00	2,700,000.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,160,000.00	2,700,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	25,885,900.00	-
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	18,487,700.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,398,200.00	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,109,625,996.00	1,705,596,595.20
2132	Бусад урсгал шилжүүлэг	256,521,685.00	511,044,800.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	256,521,685.00	511,044,800.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	40,000.00	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	40,000.00	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	853,064,311.00	1,194,551,795.20
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	853,064,311.00	1,194,551,795.20
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>(346,115,646.00)</u>	<u>655,730,404.80</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>(346,115,646.00)</u>	<u>655,730,404.80</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>792,556,250.00</u>	<u>2,364,027,000.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	40,000.00	-
120	Нийтлэг татварын бус орлого	40,000.00	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	40,000.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	40,000.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	792,516,250.00	2,364,027,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	792,516,250.00	2,364,027,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	80,335,250.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	712,181,000.00	2,359,827,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	4,200,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>1,506,490,596.00</u>	<u>2,994,296,595.20</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,506,490,596.00	2,994,296,595.20
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	29,045,900.00	2,700,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,160,000.00	2,700,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,160,000.00	2,700,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	25,885,900.00	-
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	18,487,700.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,398,200.00	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,477,444,696.00	2,991,596,595.20
2132	Бусад урсгал шилжүүлэг	599,021,685.00	1,797,044,800.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	599,021,685.00	1,797,044,800.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	25,358,700.00	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	25,358,700.00	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	853,064,311.00	1,194,551,795.20
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	853,064,311.00	1,194,551,795.20

3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>(713,934,346.00)</u>	<u>(630,269,595.20)</u>
14	Бусад эх үүсвэр	768,223,696.00	630,269,595.20
145004	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлээс эргэж төлөгдөх	768,223,696.00	630,269,595.20
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>768,223,696.00</u>	<u>630,269,595.20</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	54,289,350.00	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	768,223,696.00	
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	1,442,645,252.00	0.00	1,442,645,252.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	1,442,645,252.00	0.00	1,442,645,252.00
C07	Тайлант үеийн үр дүн				0.00
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	1,442,645,252.00	0.00	1,442,645,252.00
D01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	1,442,645,252.00	0.00	1,442,645,252.00
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	1,442,645,252.00	0.00	1,442,645,252.00
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	655,730,404.80	0.00	655,730,404.80
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	2,098,375,656.80	0.00	2,098,375,656.80

2.5 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,347,327,000.00	2,364,027,000.00	16,700,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,347,327,000.00	2,364,027,000.00	16,700,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,500,000.00	2,700,000.00	(1,800,000.00)
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,500,000.00	2,700,000.00	(1,800,000.00)
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,500,000.00	2,700,000.00	(1,800,000.00)

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,342,827,000.00	2,361,327,000.00	18,500,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,342,827,000.00	1,797,044,800.00	(545,782,200.00)
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	2,342,827,000.00	1,797,044,800.00	(545,782,200.00)
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	564,282,200.00	564,282,200.00
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг		564,282,200.00	564,282,200.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,347,327,000.00	2,364,027,000.00	16,700,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,347,327,000.00	2,364,027,000.00	16,700,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,344,827,000.00	2,359,827,000.00	15,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,500,000.00	4,200,000.00	1,700,000.00

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 2,013,061.5 мянган төгрөгийн зөрчил илэрснээс, 14,763.1 мянган төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлж, 1,998,298.4 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгсөн.

5.1 Зөвлөмж

Шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих мэдээллийг шалгахад мэдээллийг 74.8 хувьтай мэдээлсэн байна. Үүнд таван сая төгрөгөөс дээш орлогын 2,782.082.0 мянган төгрөгийн 19 гүйлгээ, зарлагын 430,194.4 мянган төгрөгийн 3 гүйлгээ, хөрөнгө мөнгө зарцуулахтай холбоотой 1,610,792.0 мянган төгрөгийн 7 тушаал шийдвэрийг мэдээлсэн байна. Шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих таван сая төгрөгөөс дээш орлогын 135,020.0 мянган төгрөгийн 4, зарлагын 1,863,278.4 мянган төгрөгийн 171 гүйлгээг мэдээлээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих мэдээллийг үнэн зөв, бүрэн мэдээлж ажиллах

5.2 Албан шаардлага

Тайлант онд байгууллагын ажилтнуудын сургалтыг зохион байгуулах, туршлага судлахтай холбоотой томилолт, шатахуун, хоол цайны материал, бичиг хэргийн зардалд 14,763.1 мянган төгрөгийг зарцуулсан байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3 “сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх” гэсэн заалтыг зөрчсөнийг дахин давтахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Мэдээллийг дутуу байршуулсан	1	1,998,298.4					1	1,998,298.4
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Төрийн хэмнэлтийн тухай хууль	1	14,763.1			1	14,763.1		
Дүн								
Нийт дүн	1	2,013,061.5			1	14,763.1	1	1,998,298.4

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаар-лалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ								
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС	1	1			1			
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1			1			